

**DPUB2**  
Монгол Улс  
дахь ХБИ-ийн  
хөдөлмөр  
эрхлэлтийг  
дэмжих  
тогтолцоог  
бэхжүүлэх  
төсөл

# DPUB2 МЭДЭЭ

№ 07  
2022 оны Долоодугаар сар

## 1. “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-ын гишүүн байгууллагуудад зориулсан семинар зохион байгууллаа

DPUB2 төсөл 6-р сарын 29-ны өдөр “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-ын хүсэлтээр “ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” нь сэдвээр семинар зохион байгууллаа.

Тус семинарт төслийн ахлах зөвлөх Чисао Хисао “Монгол Улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хуульд заасан ажил олголтын квот”-ын талаар танилцуулсан бол төслийн зохицуулагч Ц. Одгэрэл төслийн үйл ажиллагаа, сургалтын төлөвлөгөөний талаар мэдээлэл хүргэлээ. Мөн төслийн ажилтан Х.Мөнхтуул “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар” сэдвээр лекц тавьсан юм.



DPUB2, төслийн ахлах зөвлөх Хисао Чисао, төслөөс гарах үр дүн, Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт мөн квотын системийн талаар танилцуулж байна.

Оролцогчид сэтгэл өндөр байсан бөгөөд энэ удаагийн семинараас их зүйлийг мэдэж авсан гэдэгт итгэлтэй байна. Тэд ажлын байрны төлбөр, санхүүгийн дэмжлэгийн тогтолцоог сайжруулж чадвал Монгол Улсын хөгжилд том дэвшил болно хэмээн онцолж байлаа.

## 2. DPUB2 төслийн Удирдах хорооны гуравдугаар хурал зохион байгуулагдлаа



Жайкагийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дэд дарга Ёшимүра Токүжи үг хэлж байна.

DPUB2 төслийн Удирдах хорооны гуравдугаар хурал (JCC) 2022 оны 6-р сарын 30-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Хурлыг нээж Жайкагийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дэд дарга Ёшимүра Токүжи үг хэлсэн бөгөөд төслийг амжилттай хэрэгжүүлж буй ХНХЯ-д талархал илэрхийлэв.

Үүний дараа ХНХЯ-ны ХБИХХ-ийн дарга Б.Нарангарав 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг танилцууллаа. Тэрээр Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка болон ХНХЯ хамтран төлөвлөсөн ажлуудаа амжилттай хэрэгжүүлж байгааг онцолж, бидний хамтын ажиллагааны үр дүнд төслийн тогтвортой байдал хангах гол үндэс тавигдаж байгаад баяртай байна хэмээн онцоллоо.

**СЭДЭВ**

- 1 “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-ын гишүүн байгууллагуудад зориулсан семинар зохион байгууллаа
- 2 DPUB2 төслийн Удирдах хорооны гуравдугаар хурал зохион байгуулагдлаа
- 3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч байгууллагуудын сайн жишээ

Төслийн ахлах зөвлөх Чибэ Хисао 2022 оны 7-р сараас 12-р сар хүртэл зохион байгуулагдах “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар”, “ААНБ-уудад зориулсан нөлөөллийн семинар”, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй сайн жишээ зэрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцууллаа.

Хурлын төгсгөлд ХНХЯ-ны ХАХБХЗГ-ын дарга С. Тунгалагтамир Жайка болон ХНХЯ хамтран DPUB2 төслийг үр дүнтэй хэрэгжүүлж буйд талархал илэрхийлэн, ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний загвар төслийг хэрэгжүүлэхээр болсонд туйлын баяртай байгаагаа илэрхийллээ.

DPUB2 төсөл цаашид ч Монгол Улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хичээнгүйлэн ажиллах учраас та бүхэн биднийг үргэлжлүүлэн тусалж дэмжээрэй.

### 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч байгууллагуудын сайн жишээ

DPUB2 төсөл IKON.mn сайттай хамтран Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж буй байгууллага, гэр бүл, хамт олны төлөөлөл зэрэг олон талын байр суурийг онцлон тэмдэглэж, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй сайн жишээ"-г түгээх зорилгоор цуврал нийтлэл бэлтгэн хүргэж байна.

[Дугаар 1.] Макс хүнс ХХК-ийн сүлжээ дэлгүүр М-март "Хүн бүрд өөрт нь тохирсон ажлыг олж өгөх хэрэгтэй"



Ажлын байрандаа нүүр дүүрэн инээмсэглэн зогсох Э. Ихбаяр

Та бүхэн доорх линкээр нэвтрэн нийтлэлийн дэлгэрэнгүйг уншаарай.  
<https://ikon.mn/n/2kvk?fbclid>

✉ [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)

📍 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160

📘 <https://www.facebook.com/jicadpubland2>

🌐 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

